



АЖИЛ, НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

2022 оны 01 дүгээр
сарын 27-ны өдөр

Дугаар № 12

Улаанбаатар
хот

Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Засгийн газрын 2014 оны 149 дүгээр тогтоолын 4 дэх заалт, "Төсвийн байгууллагын зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай" Засгийн газрын 2003 оны 233 дугаар тогтоолыг үндэслэн нэг талаас, Зам, тээврийн хөгжлийн яам /цаашид "Захиалагч" гэх/, нөгөө талаас Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар /цаашид "Гүйцэтгэгч" гэх/ нар дараах нөхцөлийг харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээнд заасан ажил, нийтлэг үйлчилгээг явуулахад Иргэний хууль, Засгийн газрын 2014 оны 149 дүгээр тогтоолын 4 дэх заалт, Засгийн газрын 233 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхэд баримтлах чиглэл"-ийг удирдлага болгоно.

1.2. Гэрээгээр гүйцэтгэх ажил, нийтлэг үйлчилгээг нэгдүгээр, холбогдох зардлын хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлав.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

2.1. Захиалагч нь тухайн жилд худалдан авах ажил, нийтлэг үйлчилгээний нийт зардлыг төсвийн ерөнхийлөн захирагчтай тохиролцон тооцож бүрдүүлсэн байна.

2.2. Захиалагч байгууллага нь тухайн жилд гүйцэтгүүлэх ажил, нийтлэг үйлчилгээний (бүтээгдэхүүн) талаар гүйцэтгэгч байгууллагатай харилцан тохиролцож хамтран ажиллах гэрээ байгуулна.

2.3. Гүйцэтгүүлсэн ажил, нийтлэг үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд тохиролцсон хэлбэрээр шуурхай төлнө.

2.4. Ажил, нийтлэг үйлчилгээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардагдах бичиг баримт, мэдээ мэдээлэл техникийн нөхцөлөөр хангаж ажиллана.

2.5. Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажил, нийтлэг үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж хүрэх үр дүнг хангуулах талаар шаардлага тавих эрхтэй.

2.6. Захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг хариуцна.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

3.1. Гэрээний нэгдүгээр хавсралтанд заагдсан ажил, нийтлэг үйлчилгээг байгууллагын стандарт, чанарын шаардлагад нийцүүлэн хийж гүйцэтгэнэ.

3.2. Ажил, нийтлэг үйлчилгээний гүйцэтгэлд гарсан чанар, стандартын доголдлыг түргэн шуурхай хийж гүйцэтгэнэ.

3.3. Ажил, нийтлэг үйлчилгээний холбогдолтой мэдээ мэдээллийг захиалагчийн хүссэн тухай бүрт гаргаж өгнө.

3.4. Захиалагч байгууллагын өрөө тасалгаанд ажил, нийтлэг үйлчилгээ явуулахдаа тухайн байгууллагын болон ажилтан, албан хаагчдын бичиг баримт, эд зүйлс, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж, албаны болон хувийн нууцыг чандлан хадгална.

3.5. Гүйцэтгэгч нь байрын ашиглалтыг сайжруулах, хэрэглээг багасгах арга хэмжээ авсанаар гаргасан хэмнэлтийг тус байрны шаардлагатай зүйлд / засвар, үйлчилгээ гэх мэт/ зарцуулж болно.

3.6. Захиалагчтай урьдчилан тохиролцсоноор бодитойгоор гүйцэтгэсэн ажил, нийтлэг үйлчилгээний төлбөрийг нэхэмжлэн авах эрхтэй. Нэхэмжлэлд тухайн байрны нийтлэг үйлчилгээг явуулахад зайлшгүй гарах бусад зардлыг гүйцэтгэлд шингээж өгнө.

3.7. Барилга байшин, цахилгаан, ус, дулаан, сантехникийн урсгал засвартай холбоотой асуудлыг батлагдсан зардлын хүрээнд хийж гүйцэтгэж болно.

3.8. Захиалагч байгууллагын шаардлагаар үүссэн ажил, нийтлэг үйлчилгээг нэмэлт гэрээ байгуулан гүйцэтгэж болох бөгөөд нэмэлт гэрээ нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

Дөрөв. Төлбөр тооцоо

4.1. Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар нь 2022 онд Зам, тээврийн хөгжлийн яамны эзэмшиж буй хэсгийг 634 гкал дулаанаар, 234775 квт цахилгаан эрчим хүчээр, 6628 куб метр усаар тус тус хангаж, үүнтэй холбогдуулан гарах дулаан, сантехник, цахилгаан хангамж, цэвэр бохир усны төлбөр, тоног төхөөрөмж, запас сэлбэг болон аж ахуйн материал, эд хогшил, барилгын урсгал засварт үзүүлэх ажил, нийтлэг үйлчилгээний зардал болон үйлчилгээний ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглуулсаны төлбөр бусад нийтлэг үйлчилгээнд зарцуулах зардлуудад зориулан 273,199,600 төгрөг байхаар харилцан тохиролцов.

4.2. 4.1-д заасан зардлыг хавсралтанд заасан хуваарийн дагуу тогтоосон хугацаанд Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын дансанд /Худалдаа хөгжлийн банк - 499230423/ шилжүүлж байна.

4.3. Тогтмол зардлын улсаас тогтоодог нэгж үнэ нэмэгдсэн тохиолдолд нэмэгдсэн үнийн дүнгийн зөрүүгээр зардлын дүнг шууд нэмэгдүүлнэ.

4.4. Гэрээний хугацаанд ажил, нийтлэг үйлчилгээний үнэд өөрчлөлт оруулахаар бол 2 тал харилцан тохиролцож бичгээр үйлдэнэ.

Тав. Гэрээний үйлчлэх хугацаа

5.1. Гэрээний үйлчлэх хугацаа нь 2022 оны санхүүгийн тайлангийн жилд хүчинтэй байна.

5.2. Гэрээний үйлчлэх хугацааг нэг талын бичгээр гаргасан хүсэлт, нөгөө талын зөвшөөрлөөр сунгаж болно.

5.3. Талууд гэрээг гэрээний хугацаа дуусахад хамтран дүгнэж, төлбөр тооцоог харилцан дуусгаж энэ тухай акт үйлдсэнээр дуусгавар болгоно.

5.4. Талууд гэрээг нэг талын санаачилгаар цуцлахгүй.

Зургаа. Хариуцлага

6.1. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй ажил, нийтлэг үйлчилгээний үнийн дүнгийн 0.5 хувиар алданги тооцно.

6.2. Захиалагч тал ажил, нийтлэг үйлчилгээний төлбөрийг тухайн сарын 10-ны дотор шилжүүлсэн байх бөгөөд хугацаа хэтрүүлсэн үнийн дүнгийн 0.5 хувиар тооцож алданги хүлээнэ. Хэрэв зайлшгүй шаардлагаар төлбөрийг шилжүүлэх хугацаа хэтэрсэн бол шалтгаанаа албан бичгээр тайлбарлан захиалагч талд ажлын 3-5 хоногийн дотор хүргүүлнэ.

6.3. Талууд өөрсдийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг өөрсдийн зардлаар бүрэн хариуцан барагдуулна.

6.4. Алданги төлсөн, хохирол барагдуулсан үйлдэл нь талуудын гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

Долоо. Маргаан шийдвэрлэх

7.1. Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.

7.2. Талууд тохиролцоонд хүрч чадаагүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

Найм. Гэрээний хавсралт

8.1. Хавсралт № 1 . . . хуудас.

8.2. Хавсралт № 2 . . . хуудас.

Ес. Бусад зүйл

9.1. Гэрээнд талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно.


9.2. Гэрээг хоёр хувь үйлдэж тал тус бүрт нэг нэг хувийг хадгална.

9.3. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Төрийн захиргааны удирдлагын
газрын дарга


Б.Болор-Эрдэнэ

Утас: 263178

Санхүү, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга


Ч.Ренчиндамба

Утас:

1-263191

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга


Д.Мөнхтуяа

Утас: 322011, 99069499

Тооцооны нягтлан бодогч


Д.Отгонпүрэв

Утас: 263128, 99572359

Хуулийн мэргэжилтэн


Д.Өнөрсайхан

Утас: 321525

Нэг. Цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны үйлчилгээний талаар

1.1. Цахилгаан, дулаан, сантехник, цэвэр бохир усны байгууламжийн найдвартай ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг хангах.

1.2. Цахилгаан, сантехникийн бүх төрлийн урсгал засвар үйлчилгээг хугацаанд нь чанартай хийх.

1.3. Дулаан, цэвэр, бохир усыг тогтоосон хугацаанд жигд дамжуулж хэвийн горимоор хангаж ажиллана.

1.4. Сантехникийн шугам, радиатор, вентиль,крант, гоожууруудын ажиллагааг байнга шалгаж, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах.

1.5. Дулааны узелийн өрөөнүүдийн тоноглолын хэвийн ажиллагаанд байнга хяналт тавьж, үзлэг, тохируулага хийж байна.

1.6. Шугам сүлжээний их засвар, урсгал засварын ажлын хэмжээг тогтоож, тоолуурт бүрэн хамруулж аль болох хэмнэлттэй үр ашигтай ажиллах.

1.7. Цахилгааны төв цитэнд тогтмол үзлэг хийж, аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

1.8. Өрөө, тасалгаа, нийтийн эзэмшлийн гэрэлтүүлэг, унтраалга, залгуур зэрэг цахилгааны холбогдолтой засвар үйлчилгээг тогтмол хийж, хонгил, заалнуудын шатсан гэрлүүдийг шалгаж, шаардагдах үйлчилгээг хийж хэвийн үйл ажиллагааг хангах.

1.9. Цахилгааны нийт шугаманд тогтмол үйлчилгээ хийж байна.

1.10.Гол цит болон давхрын хуваарилах самбаруудад засвар, үйлчилгээ тогтмол хийж хэвийн ажиллагааг хангаж байх.

1.11.Мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэмжилт хийж баталгаажуулах. Дулаан, цэвэр бохир ус, цахилгааны гэрээг зохих байгууллагатай байгуулж, төлбөр тооцоог сар тутам хийж байх.

Хоёр. Барилгын урсгал засвар, мужааны үйлчилгээ

2.1. Яамны эд хогшил, тавилгын эвдрэл гэмтлийг тухай бүр сэлбэн, засварлахад тусална.

2.2. Өрөө тасалгаа, нийтийн эзэмшлийн газрын шал, хаалга, цонх, салхивч засварлах, шиллэх, дулаалах, хаалганы нугас, бариул, түгжээ, цоож хийх суулгах, засварлах зэрэг ажил хийнэ.

2.3. Албан ёсоор харилцан тохиролцсоны дагуу барилгын урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.

Гурав. Цэвэрлэгээ үйлчилгээний талаар

- 3.1. Албан өрөөний өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг стандартын дараалал баримтлан ажиллаж цэвэр орчинг бүрдүүлнэ.
- 3.2. Их цэвэрлэгээг технологийн дагуу сард 2 удаа хийх.
- 3.3. Хивс дрозийг зориулалтын машинаар сард 1-ээс доошгүй удаа угааж байх.
- 3.4. Өрөөнүүдэд байрлах цэцэг болон ногоон байгууламжийн арчилгааг тогтмол хийнэ.
- 3.5. Нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ үйлчилгээг стандартын дагуу тогтмол хийх.
- 3.6. Нийт өрөө тасалгаанд жилд 2 удаа хортон шавьжийн устгал, халдваргүйжүүлэлт хийх.
- 3.7. Өвлийн бэлтгэлийн ажлыг цаг тухайд нь хангаж, цонхыг дулаалж байх.
- 3.8. Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ үйлчилгээ ариутгалын ажиллагааг стандартын дагуу гүйцэтгэж хэвийн байдлыг хангана.

Дөрөв. Цайны өрөөний үйлчилгээ

- 4.1. Яамны нийт ажиллагсдад цай, буцалсан усаар үйлчилнэ. / Шаардлагатай нөхцөлд аарц болон бусад нэмэгдэл үйлчилгээ үзүүлнэ./
- 4.2. Захиалагч байгууллагад болох хурал зөвлөлгөөн, семинарт кофе, цайгаар үйлчлэх.
- 4.3. Захиалагч байгууллагад ирэх зочдын үйлчилгээнд кофе, цэвэр ус, цай, чихэр самар буюу шинэ жимсээр үйлчлэх. /Холбогдох зардлыг яам хариуцна./
- 4.4. Цайны үйлчилгээнд хэрэглэж байгаа сальфетик, скатерийг цэвэр үзэмжтэй байлгах.
- 4.5. Буфетийн үйлчилгээг үзүүлж болно.

**Зам тэвэрийн хөгжлийн яам, Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын хооронд
20... оны ...-р сарын ...-ны өдөр байгуулсан 12 тоот гэрээний хоёрдугаар хавсралт**

№	Үйлчилгээний нэр	нийт төсөв	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
	Байрны нийт талбай м2							2499.50						
	Өрөөний талбай м2							1791.30						
	Нийтийн эзэмшил							708.20						
1	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	273,199.60	22,767.00	22,766.60	22,766.60	22,766.60	22,766.60	22,766.60	22,766.60	22,766.60	22,766.60	22,766.60	22,766.60	22,766.58
	1м2 талбайд зарцуулах зардал	109.30	9.11	9.11	9.11	9.11	9.11	9.11	9.11	9.11	9.11	9.11	9.11	9.11

Тайлбар: 2022 онд ажилчдын цалин хөлс, гэрэл цахилгаан, тули халаалт, цэвэр бохир усны үнэд өөрчлөлт оруул тухай бүр нь тодотгол хийхээр гэрээнд заасан болно.

Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч

/Г.Алтангэрэл /

Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга

Б.Мянхтүвшин /Д.Мөнхтүяа/
Утас: 263128, 99069499

Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн

/О.Очгэрэл/

Утас: 99270909

Тооцооны нягтлан бодогч

/Д.Отгонпүрэв/

Утас: 263128, 99572359

**Зам тээврийн хөгжлийн яам, Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын хооронд
20... оны ...-р сарын ...-ны өдөр байгуулсан 12 тоот гэрээний хөбрдугаар хавсралтын задаргаа**

№	Үйлчилгээний нэр	нийт төсөв	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
Байрны нийт талбай м2														
2499.50														
Өрөөний талбай м2														
1791.30														
Нийтийн эзэмшил														
708.20														
1	ажилчид	145,200.00	12,100.00	12,100.00	12,100.00	12,100.00	12,100.00	12,100.00	12,100.00	12,100.00	12,100.00	12,100.00	12,100.00	12,100.00
	НДШ	18,150.00	1,512.50	1,512.50	1,512.50	1,512.50	1,512.50	1,512.50	1,512.50	1,512.50	1,512.50	1,512.50	1,512.50	1,512.50
Цалингийн дүн		163,350.00	13,612.50	13,612.50	13,612.50	13,612.50	13,612.50	13,612.50	13,612.50	13,612.50	13,612.50	13,612.50	13,612.50	13,612.50
2	Түлш халаалт	14,276.06	2,039.44	2,039.44	2,039.44	2,039.44						2,039.44	2,039.44	2,039.44
	Гэрэл цахилгаан	30,056.94	2,504.75	2,504.75	2,504.75	2,504.75	2,504.75	2,504.75	2,504.75	2,504.75	2,504.75	2,504.75	2,504.75	2,504.75
3	Цэвэр, бохир ус	10,882.18	490.18	490.18	490.18	490.18	1,490.18	1,490.18	1,490.18	1,490.18	1,490.18	490.18	490.18	490.18
	Тогтмол зардлын дүн	55,215.19	5,034.36	5,034.36	5,034.36	5,034.36	3,994.93	3,994.93	3,994.93	3,994.93	3,994.93	5,034.36	5,034.36	5,034.36
3	БГАҮйлчилгээ /Хангамжийн зүйлс, төлбөр, хураамж, бусад зардал г.м /	54,634.41	4,120.14	4,119.74	4,119.74	4,119.74	5,159.17	5,159.17	5,159.17	5,159.17	5,159.17	4,119.74	4,119.74	4,119.72
	Нийт зардлын дүн	273,199.60	22,767.00	22,766.60	22,766.60	22,766.60	22,766.60	22,766.60	22,766.60	22,766.60	22,766.60	22,766.60	22,766.60	22,766.60
1м2 талбайд зарцуулах зардал		109.30	9.11	9.11	9.11	9.11	9.11	9.11	9.11	9.11	9.11	9.11	9.11	9.11

Тайлбар: 2022 онд ажилчдын цалин хөлс, гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны үнэд өөрчлөлт орвол тухай бүр нь тодотгол хийхээр гэрээнд заасан болно.

Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч
/Г.Алтангэрэл /

Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн
/О.Очир /

Утас: 99270909

Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга
/Д.Мөнхтуяа /

Тооцооны нягтлан бодогч
/Д.Отгонпүрэв /

Утас: 263128, 99069499

Утас: 263128, 99572359

